

**“ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН НЭГДСЭН ТӨВ” УТУГ-ЫН
НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-
ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН**

2023 оны 05 дугаар сарын 09-ний өдөр

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах, Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны “Шил ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” 01 дүгээр албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн А/123 дугаар тушаалын хавсралтаар баталсан төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээний ажлыг гүйцэтгэлээ.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал.

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”, 2022 оны 352 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Нийтийн мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-ыг тус тус үндэслэл болгосон.

Гурав. Нийтийн мэдээллийн ил тод байдлын хэрэгжилт.

№	№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилтийн байдал	Тайлбар
Нэг. Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал				
1	1.1	Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн	“Эрхэм зорилго”-ыг цахим хуудасны “Бидний тухай” булангийн “Зорилго” хэсэгт http://rtcc.mrtd.gov.mn/11/single болон мэдээллийн самбарт байршуулсан. “Үйл ажиллагааны стратегийн үндсэн зорилго”-ыг цахим хуудасны “Үйл ажиллагаа” булангийн “Стратегийн зорилтууд” хэсэгт http://rtcc.mrtd.gov.mn/8/single байршуулсан. “Тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн”-г цахим хуудасны “Үйл ажиллагаа” булангийн “Үйл ажиллагааны тайлан” хэсэгт сар бүр http://rtcc.mrtd.gov.mn/file/30 байршуулсан. Төвийн үйл ажиллагаатай холбоотой 30 мэдээ мэдээллийг цахим хуудасны “Мэдээ, мэдээлэл” булангийн “Мэдээ” хэсэгт http://rtcc.mrtd.gov.mn/21/all байршуулсан. Мөн олон нийтийн сүлжээ болон “Ганзам” сонинд нийтлүүлсэн. “Мэдээ, мэдээлэл” булангийн “Мэдээлэл” хэсэгт төмөр замын салбарын бүтээн байгуулалтын талаарх мэдээллийг байршуулан ажилласан. http://rtcc.mrtd.gov.mn/56/all	30 мэдээллийн 4-ийг энэ онд байршуулсан. Тус 4 мэдээллийг татаж авах, харах боломжгүй байна. 2022, 2023 оны ГТ-г нийтлэх. 2022 оны онцлох тайлан контентийг байршуулах. 2022, 2023 оны ГТ-ний биелэлтийг оруулах.
2	1.2	Чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах,	Чиг үүргийг “Бидний тухай” булангийн “Хэлтэс” хэсэгт http://rtcc.mrtd.gov.mn/40/single , “Бүтэц, зохион байгуулалт”-ыг цахим хуудасны “Бидний тухай” булангийн “Төвийн бүтэц” хэсэгт байршуулсан http://rtcc.mrtd.gov.mn/12/single . Хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг,	Фэйсбүүк хаягийг байршуулах

		мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг	олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаягийг цахим хуудасны нүүр хэсэгт http://rtcc.mrtd.gov.mn/ байршуулсан.	
3	1.3	Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж	Үйл ажиллагааны тайланг “Үйл ажиллагаа” булангийн “Үйл ажиллагааны тайлан” хэсэгт сар бүр http://rtcc.mrtd.gov.mn/file/30 байршуулсан. ГТХЗНТ-ийн үйл ажиллагааны явц, үр дүнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг төвийн цахим хуудасны “Ил тод байдал” булангийн “Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит” буланд 1,2,3,4 дүгээр сарын дотоод үйл ажиллагааны хяналт шинжилгээ, үнэлгээний тайланг байршуулж мэдээллэж байна. http://rtcc.mrtd.gov.mn/29/all	Хяналт-шинжилгээ, үнэлгээний 4,5,6,7,8,9 тайланг байршуулах.
4	1.4	Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан	Байхгүй	
5	1.5	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан	Байхгүй	
6	1.6	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт	“Хууль эрх зүй” булангийн “Монгол Улсын хууль” хэсэгт Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Иргэний хууль, Монгол хэлний тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль шинэчилсэн найруулга, Төмөр замын тээврийн тухай хууль, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хууль, Захиргааны ерөнхий хууль, Зөрчлийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хууль, мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Шилэн дансны тухай гэсэн 29 хуулийг http://rtcc.mrtd.gov.mn/file/20 , “Улсын Их Хурлын тогтоол” хэсэгт Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх тухай, Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай /37-р тогтоол/, Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого батлах тухай /32-р тогтоол/ http://rtcc.mrtd.gov.mn/file/31 , “Засгийн газрын тогтоол” хэсэгт Засгийн газрын 20 тогтоолыг http://rtcc.mrtd.gov.mn/file/32 , “Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаал” хэсэгт ЗТХ-ийн сайдын 27 тушаал, сайдын зөвлөлийн хуралдааны тэмдэглэл 2, дотоод аудитын хорооны тогтоол 1, http://rtcc.mrtd.gov.mn/file/33 “Дүрэм журам” хэсэгт захирлын тушаалаар баталсан 22 тушаалыг шинээр байршуулж тухай бүр шинэчилж байна. http://rtcc.mrtd.gov.mn/file/34	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль хүчингүй болсон, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг байршуулах. ЗТХ-ийн сайдын 2023 онд баталсан тушаалууд болон сайдын 01, 02, 04 дүгээр албан даалгаврыг байршуулж мэдээлэл шинэчлэх. Дүрэм, журам буланд захирлын тушаалаар шинэчлэн баталсан холбогдох журмыг нэмж байршуулах.
7	1.7	Албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны	Төвийн албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаягийг “Бидний тухай” булангийн	Албан тушаал, ажилтнуудын нэрсийг 1

		харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг	“Хэлтэсүүд” хэсэгт чиглэл чиглэлээр байршуулан тухай бүр шинэчлэж байна. Захиргаа санхүүгийн хэлтэс http://rtcc.mrtd.gov.mn/40/single , Тээврийн нэгдсэн удирдлага, автоматжуулалт, судалгааны хэлтэс- http://rtcc.mrtd.gov.mn/38/single , Гэрчилгээжүүлэлт, хөдлөх бүрэлдэхүүн ашиглалт, бүртгэл, мэдээллийн хэлтэс- http://rtcc.mrtd.gov.mn/37/single	форматад оруулах. АТТ-д нэмэлт оруулах тухай 2021 оны А/21, 2023 оны А/05 дугаар тушаалыг нэмж болох юм.
8	1.8	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ	Өргөдөл гомдол хариуцсан албан хаагчийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утасыг “Санал хүсэлт” буланд http://rtcc.mrtd.gov.mn/app байршуулсан. Цахим хуудасны “Үйл ажиллагаа” булангийн “Санал хүсэлтийн шийдвэрлэлт” хэсэгт Төвийн өргөдөл, гомдол, хариутай албан бичгийн шийдвэрлэлтийн сар болон улирлаар, Гэрчилгээжүүлэлтийн шийдвэржилт, Хөдлөх бүрэлдэхүүний дугаар олголтыг 1 дүгээр улирлын байдлаар байршуулсан. http://rtcc.mrtd.gov.mn/53/all байршуулсан.	Шийдвэрлэх хугацаа хэтэрсэн баримт бичгийг мэдээг нэмж болох юм.
9	1.9	Хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл	Салбарын үйл ажиллагааны статистик мэдээллийг цахим хуудасны “Мэдээ, мэдээлэл” булангийн “Статистик мэдээ” хэсэгт 1,2,3 дугаар сарын ачаа, тээврийн статистик мэдээг инфографик хэлбэрээр байршуулан ажиллаж байна. http://rtcc.mrtd.gov.mn/22/all/	
10	1.10	Мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр	Төвөөс зохион байгуулж буй олон нийтийг хамарсан арга хэмжээний талаар тухай бүр төвийн цахим хуудасны “мэдээ, мэдээлэл” булангийн “мэдээ” хэсэгт байршуулсан. http://rtcc.mrtd.gov.mn/22/all . Суурь бүтэц хооронд дамжин өнгөрөх ачааны хэмжээ тохиролцох анхдугаар зөвлөгөөнийг 2023.03.23-ны өдөр амжилттай зохион байгуулсан. Зөвлөгөөнд ЗТХЯ, “ГТХЗНТ” УТҮГ болон монгол улсад төмөр замын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг, суурь бүтэц эзэмшигч “УБТЗ” ХНН, “МТЗ” ТӨХК, “Тавантолгой төмөр зам” ХХК, “Монголиантранс лайн” ХХК, “Монголиантранс ложистик” ХХК-ийн байгууллагуудын төлөөллүүд оролцсон. Суурь бүтцүүдээр 2023 онд дамжуулан тээвэрлэх ачааны хэмжээг тохирох, галт тэрэгний хөдөлгөөн зохион байгуулалтын талаар, ачаа тээврийн ажлын зохион байгуулалтын талаар, хөдлөх бүрэлдэхүүний ашиглалтын талаар, нэгдсэн технологийн горимын төслийн талаар хэлэлцэж шийдвэрт хүрч, гарын үсэг зурж баталгаажуулсан.	2023.05.25-ны өдөр зохион байгуулагдах “Төмөр замын салбарт-хөдөлгөөний аюулгүй байдал” сэдэвт зөвлөгөөний Хөтөлбөрийг байршуулах.
Хоёр.Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал				
11	2.1	Ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл	2023 оны 04 дугаар сарын 31-ны байдлаар сул орон тоо гараагүй.	Ажлын байрны 5 сул орон тооны мэдээлэл байршуулсан байна.
12	2.2	Албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам	Ажилтан сонгон шалгаруулах журмыг төвийн цахим хуудасны “Ил тод байдал” булангийн “Хүний нөөцийн ил тод байдал” хэсгийн “Хүний хөөцийн удирдлага” цэсэнд http://rtcc.mrtd.gov.mn/44/item/283 байршуулсан.	

13	2.3	Албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм	"ГТХЗНТ" УТУГ-ын ажилтны ёс зүйн дүрмийг төвийн цахим хуудасны "Хууль, эрх зүй" булангийн "Дүрэм, журам" хэсэгт http://rtcc.mrtd.gov.mn/upload/files/1fb1088e2b862addbe59e223f1654add.pdf байршуулсан.	Тушаалын төсөл ¹ болон албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоосон тушаал ² хамтад нь оруулсныг засах.
14	2.4	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам	Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн баталж, төвийн цахим хуудасны "Хууль, дүрэм журам" булангийн "Дүрэм, журам" хэсэгт http://rtcc.mrtd.gov.mn/upload/files/47548a9a695a46753d4e1389a5a6a981.pdf байршуулсан.	2023 онд 1 мэдээлэл оруулсан байна.
15	2.5	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ		Биелэлтийг тайлагнаж байх. 2023 онд 16 мэдээлэл оруулсан байна.
16	2.6	Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам		Биелэлтийг тайлагнаж байх. Сар, улирлаар ажлын үр дүнг үнэлж дүгнэж байгаа юу?
Гурав. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал				
17	3.1	Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл	2022 оны төсвийн гүйцэтгэл нь шилэн дансны цахим системийн 12 дугаар сарын холбогдох талбарт мэдээлэгдсэн. 2023 оны урсгал санхүүжилтийн батлагдсан төсөв нь шилэн дансны цахим системийн сар бүр бэлтгэн мэдээлэх талбарт тогтмол мэдээлэгдэж байна. 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024, 2025 оны төсвийн төсөөлөл бэлтгэгдэж байгаа бөгөөд тайлагнах хугацаа хүлээгдэж байна.	https://shilendans.gov.mn/organization/45258 цахим хуудсанд байршуулсан байна.
18	3.2	Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан	Сар бүрийн төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн дараа сарын 2-ны дотор харьяа төрийн санд хүргэн баталгаажуулж шилэн дансны цахим системд тогтмол байршуулан мэдээлж байна.	https://shilendans.gov.mn/organization/45258 цахим хуудсанд байршуулсан байна.
19	3.3	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт	Сар бүрийн төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн дараа сарын 2-ны дотор харьяа төрийн санд хүргэн баталгаажуулж шилэн дансны цахим системд тогтмол байршуулан мэдээлж байна.	
20	3.4	Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ	Төвийн чиг үүргийн хувьд төлбөр хураамж төвлөрүүлэх чиг үүрэг байдаггүй.	

21	3.5	Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар	2023 оны 5 дугаар сарын байдлаар төсвийн гүйцэтгэлийн хэмнэлт хэтрэлтийн тайлбар, шалтгааныг шилэн дансны цахим системийн холбогдох талбарт 5 удаа байршуулан мэдээлээд байна.	https://shilen.dans.gov.mn/organization/45258 цахим хуудсанд байршуулсан байна.
22	3.6	Таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг	Төв нь 5 544 000/таван сая таван зуун дөчин дөрвөн мянган/ төгрөгний оффис түрээсийг сар бүр төлдөг бөгөөд тухай бүр шилэн дансны цахим системд байршуулан мэдээлж байна.	
23	3.7	Цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт	Шилэн дансны холбогдох талбарт сар бүрийн санхүүжилтийн орлого, оффис түрээсийн төлбөрийн зарлагыг 2023 оны 5 дугаар сарын байдлаар 5 удаа байршуулан мэдээлээд байна.	
24	3.8	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр	Байгууллагын дотоод журам, Хамтын гэрээ, ХАБЭА-н төлөвлөгөөний хүрээнд төвийн албан хаагчдыг витаминжуулах тухай, Захиргаа санхүүгийн хэлтсийн дарга Б.Энхжаргалд буцалтгүй тэтгэмж олгох тухай төвийн захирлын тушаал гарсаныг шилэн дансны цахим системд байршуулаад байна.	
25	3.9	Шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл	2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг шилэн дансны цахим системд байршуулсан бөгөөд зөвлөмжийн хэрэгжилтийг байршуулах хугацаа болоогүй тул эрх нээгдээгүй.	
26	3.10	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан	Төвийн 2023 оны урсгалт төсөвт тендерийн үйл ажиллагаа зохион байгуулж худалдан авалт хийх төлөвлөгөө тусгагдаагүй.	
27	3.11	Худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит,	2023 оны 5 дугаар сарын байдлаар энэ төрлийн хяналт,шалгалт хийгдээгүй.	

		бусад хяналт шалгалтын тайлан, дүгнэлт		
28	3.12	Мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл	2023 оны 4 дүгээр сарын байдлаар 3.12-т холбогдох шаардлага үүсээгүй.	
29	3.13	Төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн	Байхгүй	
30	3.14	Мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан	2023 оны 05 дугаар сарын байдлаар байхгүй.	
31	3.15	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд оролцох эрхийг хязгаарласан этгээдийн жагсаалт	3.15-д хамаарах мэдээлэл байхгүй.	
32	3.16	Засгийн газрын гадаад улс, олон улсын байгууллагаас авсан зээл, тусламжийн гэрээ, хэлэлцээрийн талаарх мэдээлэл	Засгийн газрын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 3.6.1.3-т “Төмөр замын хөдөлгөөний нэгдсэн удирдлагын төвийн барилга барих төсөл”-ийг БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага /КОЙКА/-ын буцалтгүй тусламжаар хамтран хэрэгжүүлэхээр 2021 оны 8 дугаар сард хэлэлцээрийн протоколыг баталсан байна. 2023 оны 5 дугаар сарын байдлаар төслийн барилгын зураг төслийн ажил хийгдэж байна.	Үйл ажиллагаа булангийн Төсөл, хөтөлбөр буланд Мэдээлэл, зураг байршуулсан байна.
33	3.17	Улсын төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсвийн орлого, зарлага, хөрөнгө оруулалт, төсвийн нэгдсэн үзүүлэлт	Байхгүй	
34	3.18	Засгийн газрын гадаад зээл, тусламжийн ашиглалтын мэдээлэл	Байхгүй	
35	3.19	Засгийн газрын гадаад, дотоод өрийн мэдээлэл	Байхгүй	
36	3.20	Улсын төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар	Байхгүй	
37	3.21	Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ	Байхгүй	
38	3.22	Төсвийн гүйцэтгэл болон аудит хийсэн	Байхгүй	

		санхүүгийн нэгтгэсэн тайлан		
39	3.23	Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан Засгийн газрын дотоод үнэт цаасны мэдээлэл	Байхгүй	
40	3.24	Концессын зүйлийн жагсаалт болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт	Байхгүй	
41	3.25	Концессын гэрээ байгуулсан тухай бүрд концесс эзэмшигч, түүний байгууллагын нууцад хамаарахаас бусад мэдээлэл, концессын зүйл, гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээлэл	Байхгүй	
42	3.26	Хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан Засгийн газрын гадаад үнэт цаасны мэдээлэл	Байхгүй	
43	3.27	Улсын төсвийн нэгдсэн үзүүлэлтийг макро эдийн засгийн үзүүлэлт, холбогдох бусад үзүүлэлттэй уялдуулсан судалгаа, тооцоо	Байхгүй	
44	3.28	Орон нутгийн төсвийн төсөлд санал авах талаарх хэлэлцүүлгийн мэдээлэл	Байхгүй	
Дөрөв. Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал				
45	4.1	Үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл	Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагааны гэрчилгээжүүлэлтийн журам, бүрдүүлэх материалыг шинэчлэн, 2019-2022 онд гэрчилгээ шинээр олгосон, сунгасан, хүчингүй болгосон иргэн, хуулийн этгээдүүдийн бүртгэлийг төвийн цахим хуудасны “Үйл ажиллагаа” булангийн “Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагааны гэрчилгээ” хэсэгт http://rtcc.mrttd.gov.mn/55/all мөн олон нийтийн сүлжээнд контент хэлбэрээр тус тус байршуулсан. https://www.facebook.com/Rtcc.m0n . Гэрчилгээжүүлэлтийн сар бүрийн шийдвэржилтийг статистик үзүүлэлтээр гарган төвийн цахим хуудасны “Мэдээ, мэдээлэл” булангийн “Мэдээ” хэсэгт болон олон нийтийн сүлжээнд сар бүр байршуулж байна. http://rtcc.mrttd.gov.mn/21/all , https://www.facebook.com/Rtcc.m0n МУ-ын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүнд дугаар олгоход шаардагдах баримт бичгийн жагсаалт болон журамыг “Үйл ажиллагаа” булангийн “Хөдлөх бүрэлдэхүүний дугаар олголт” хэсэгт байршуулсан. http://rtcc.mrttd.gov.mn/20/all . Дугаар олголтын статистик мэдээг сард хоёр удаа гарган “Мэдээ, мэдээлэл” булангийн “Мэдээ” хэсэгт болон олон нийтийн сүлжээнд сард 2 удаа байршуулж байна.	

			http://rtcc.mrtd.gov.mn/21/all , https://www.facebook.com/Rtcc.m0n	
46	4.2	Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам, олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон зөвшөөрлийн талаарх мэдээлэл, зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа.		Биелэлтийг тайлагнаж байх. ТЗАБХ-той объект, үйл ажиллагаанд гэрчилгээ олгосон мэдээллийг 2023.04.13-нд байршуулсан байна.
Тав.Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал				
47	5.1	Олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн санал	Төвийн цахим сайтын нүүр хэсэгт “Санал авч байна” хэсэгт “Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журам” болон “МУ-ын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл хөтлөх, хүлээлцэх журам”-д нэмэлт өөрчлөлт оруулах санал авч байна. http://rtcc.mrtd.gov.mn/ .	
48	5.2	Эзэмшиж байгаа оюуны өмчийн эрхийн жагсаалт	Байхгүй	
49	5.3	Хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийн явцын талаарх мэдээлэл	Байхгүй	
50	5.4	Мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл		Газрын мэдээллийг оруулах.
51	5.5	Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг	Байхгүй	
52	5.6	Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын	Байхгүй	

		зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн, албаны цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах ажиллагааны тов, сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээлэл		
53	5.7	Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хувьд нэгдсэн төсөв болон Үндэсний баялгийн санд оруулж байгаа татвар, хөрөнгийн хэмжээ	Байхгүй	
54	5.8	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэл	Байхгүй	
55	5.9	Хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээний явцад байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл, үр дагавар, тэдгээрийг арилгах арга хэмжээг тогтоосон байгаль орчны нөлөөллийн үнэлгээний талаарх мэдээлэл, газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн мэдээлэл	Байхгүй	
56	5.10	Мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник,	Байхгүй	

		технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл		
57	5.11	Барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт	Байхгүй	
58	5.12	Тусгай хамгаалалттай газар нутаг дэвсгэрт олгосон газар ашиглах гэрчилгээ, байгуулсан гэрээ, газар ашигласны төлбөр төлөлтийн байдал	Байхгүй	
59	5.13	Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээ	Байхгүй	
60	5.14	Шүүн таслах ажиллагааны дүн мэдээ	Байхгүй	
61	5.15	Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд гаргасан өргөдөл, гомдол, хүсэлтийн дагуу маргаан хянан шийдвэрлэсэн ажиллагааны дүн мэдээ	Байхгүй	
62	5.16	Улс төрийн намын дүрэм, гишүүнчлэл, хөрөнгө, түүнд өгсөн хандивын мэдээлэл	Байхгүй	
63	5.17	Монгол Улсын нэгдэн орсон олон талт олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэг, хүргүүлсэн тайлан, Монгол Улсад өгсөн зөвлөмж, зөвлөмжийн хэрэгжилтийг хариуцах байгууллагын талаарх мэдээлэл	Байхгүй	
64	5.18	Зүй ёсны монополь аж ахуй эрхлэгчийн үнийн бүрдлийн мэдээлэл болон давамгайл байдлтай аж ахуй эрхлэгчийн жагсаалт	Байхгүй	
65	5.19	Хуулийн этгээдийн эцсийн эзэмшигч,	Байхгүй	

		эцсийн өмчлөгчийн талаарх мэдээлэл		
66	5.20	Мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн, гэрээний хэрэгжилт	Байхгүй	
67	5.21	Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчилсан байдал, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан		2022 оны авлигын төлөвлөгөө, биелэлт, 2023 оны төлөвлөгөө, Үүрийнтуяагийн сургалтын слайдыг нийтлэх.
68	5.22	Албан тушаалтны Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8.1-д заасан ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл болон энэ хуулийн 8.6-д заасан тайлбар		Гэрчилгээ-жүүлэлтийн Ажлын хэсгийн гишүүд АСЗТМ-ийг тухай бүр гаргаж байгаа, энэ мэдэгдэл хаана тавигддаг вэ
69	5.23	Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг хянасан дүгнэлт	Байхгүй	
70	5.24	Төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн албан хаагчийн нөөцийн бүртгэл	Байхгүй	
71	5.25	Хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл	Байхгүй	

Дөрөв. Үнэлгээ.

№	Шалгуур үзүүлэлтийн төрөл	Нээлттэй мэдээлэх мэдээллийн тоо	Үүнээс /хувиар/					Хэрэгжилт ийн дундаж хувь
			100	70	30	0	Хугацаа болоогүй	
1	Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	8	4	3	1	-	-	80.0
2	Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	6	4	1	1	-	-	83.3
3	Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	8	6	-	1	-	1	90.0
4	Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	2	2	-	-	-	-	100
5	Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал	4	2	-	1	1	-	57.5
Дүн		28	18	4	4	1	1	81.4

Тав. Дүгнэлт.

1. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг 2022.05.01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн.

2. “ГТХЗНТ” УТҮГ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт болон үйл ажиллагаанд 2022 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлан ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2023.03.22-ны өдрийн 03/1283 дугаартай албан бичгээр ирсэн. Тус тайланд мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг 5 төрөл, 32 үзүүлэлтээр үнэлж дүгнэсэн байна.

3. ЗТХЯ-ны үнэлгээгээр төвийн үйл ажиллагааны ил тод байдлыг **87.5%**, хүний нөөцийн ил тод байдлыг **71.7%**, төсөв санхүүгийн ил тод, нээлттэй байдлыг **44.4%**, үзүүлж буй үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг **100%**, бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг **70%**, хэрэгжилтийн дундаж **68%**-тай үнэлэгдсэн.

4. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд зааснаар байнга ил тод, нээлттэй байлгах 71 мэдээллээс 28 нь төвийн үйл ажиллагаатай хамааралтай, 43 нь хамааралгүй мэдээлэл байна.

5. Нээлттэй мэдээлэх 28 мэдээллийн 22 мэдээлэлд биелэлтийг тайлагнаж, 6 мэдээлэлд биелэлт гаргаагүй байна.

6. Төвийн цахим хуудсанд байршуулж мэдээлсэн мэдээлэлд дүн шинжилгээ хийхэд нийт мэдээллийн **1** буюу 0.16%-ийг 2017 онд, **39** буюу 6.31%-ийг 2018 онд, **47** буюу 7.61%-ийг 2019 онд, **61** буюу 9.87%-ийг 2020 онд, **115** буюу 18.61%-ийг 2021 онд, **137** буюу 22.17%-ийг 2022 онд, **102** буюу 16.5%-ийг 2023 онд байршуулсан, байршуулсан хугацаа мэдэгдэхгүй мэдээлэл **116** буюу 18.77%-ийг тус тус эзэлж байна.

Зургаа. Санал зөвлөмж.

1. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тайлан нь төвийн үйл ажиллагааг хагас, бүтэн жилээр үнэлж, дүгнэх нэг үзүүлэлт болдог учир төвийн цахим хуудсанд байршуулж нийтлэх мэдээлэл, мэдээлэх хугацаа, мэдээллийн чанар, тогтмол байдалд анхаарч ажиллах;

2. Цахим хуудсанд нийтэлж буй мэдээллийн гарчиг, мэдээллийн агуулга, найруулга зүй, үг үсгийн алдааг сайтар хянаж, нэг форматад оруулж нийтлэх, байршуулсан мэдээллийн бүртгэл хөтлөх;

3. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Засгийн газрын 2022 оны 201 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Нийтийн мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам”, Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Нийтийн мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-ыг судалж хэрэгжүүлэх, энэ чиглэлийн хууль тогтоомжийн мэдлэг олгох сургалт, мэдээллийн арга хэмжээ зохион байгуулж ажил үүргийн хуваарь, чиглэлийн дагуу холбогдох ажилтнуудыг хамруулах;

4. ЗТХЯ-ны цахим хуудас <https://mrt.d.gov.mn/i/3480> байршуулж мэдээлсэн нээлттэй мэдээллийн жишгээр төвийн цахим хуудсанд тусдаа булан бий болгож мэдээлэл нийтлэх, шинэчлэх;

5. Засгийн газрын 2022 оны 201 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Нийтийн мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, хяналт тавих нийтлэг журам”-д нийцүүлэн “Цахим хуудас, олон нийтийн сүлжээнд мэдээлэл, контент байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих журам”-ыг батлуулж мөрдөх.

ТАНИЛЦСАН:


“ГТХЗНТ” УТУГ-ЫН ЗАХИРАЛ


ТНУАСХ-ИЙН ДАРГА


ГХБАБМХ-ИЙН ДАРГА


БОЛОВСРУУЛСАН:

ХШҮМ


А.БУЯННЭМЭХ


Д.ТӨГСЖАРГАЛ


Ц.ОЮУНБАТ


Э.ОСОРЖАМАА